1558

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ НАЦАГДОРЖИЙН ЭНХТАЙВАНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”** | | | | | | | |
| 1. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 06 дугаар сарын 15-ны байдлаар тэсрэх бодис 160.7 тн, тэсэлгээний хэрэгсэл 6701.2 тн, бордоо 6159 тн, тэсрэх түүхий эд 35019 тн, ариутгал, халдваргүйтгэлийн бодис 86 тн, ахуйн хортон шавьж, устгагч 16,1 тн, ургамал хамгааллын бодис 1271,1 тн, 16055 тн дээр дурьдсанаас бусад химийн хорт болон аюултай бодист хяналт, шалгалт хийж улсын хилээр нэвтрүүлсэн байна.<br><br>Хяналт шалгалтын явцад 6 аж ахуйн нэгжид холбогдох хаяг шошго, | 1.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна.<br>2. Химийн хорт болон аюултай бодисын хяналт, шалгалттай хамааралтай Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын биелэлт; Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт зэрэг | ***<u>Эхний хагас жил</u>*** 2024 оны 06 дугаар сарын 05-ны байдлаар Замын-Үүд, Чингис хаан, Сүхбаатар, Алтанбулаг, Баянхошуу, Бичигт, Гашуунсухайт боомтоор химийн хорт болон аюултай бодис 23548.4 тн, бордоо 11093 тн, ургамал хамгаалын бодис 400 тн, ариутгал халдваргүйтгэлийн бодис 193 тн, ахуйн хортон шавьж устгалын бодис 12 тн, тэсрэх бодисын түүхий эд 100905 тн, тэсрэх бодис 603.5 тн, тэсрэх материал 149 кг, 14481600 метр, 4571146 ширхэг, пиротехникийн хэрэгсэл 41.2 кг тус тус хяналт, шалгалтад хамрагдаж нэвтэрсэн байна.<br><br>Хяналт шалгалтын явцад хаяг шошго болон тээвэрлэлтийн шаардлага хангаагүй 4, | 2024.01.02-2024.06.05 | 98 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | стандартын шаардлага хангаагүй 4, тээвэрлэлтийн шаардлага хангаагүй 4, экспортлогч талын чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын баримт бичиггүй 1 зөрчлийг тус тус илрүүлж, 18 сая төгрөгийн шийтгэл оногдуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | холбогдох тогтоол, шийдвэрийн хорио цээрийн хяналттай холбоотой заалтын биелэлтийг гаргаж тайлагнана. | экспортлогч талын чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын баримт бичиггүй 1, буруу мэдүүлсэн 1 зөрчлийг тус тус илрүүлэн зөрчлийг арилгуулж 18.0 сая төгрөгийн шийтгэл ногдуулж хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. 1 аж ахуйн нэгжийн 42 нэрийн химийн бодисыг тусгай зөвшөөрөлгүй хилээр нэвтрүүлэхийг завдсан зөрчилд зөрчлийн хэрэг үүсгэн зөрчилд холбогдсон эд зүйлсийг хураан авсан.<br>Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээни хэрэгслийн эргэлтэд хяналт тавих хуулийн импортлохтой холбоотой заалтын хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж ЗУГ-т хүргүүлсэн. | | |
| 2. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Озон задалдаг бодис, орлуулах бодис болон тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, тусгай зөвшөөрлийн стандарт үйл ажиллагааны журамд санал өгөв.<br>-Гаалийн хяналт, шалгалтын нийтлэг журмын төсөл дээр | 1.Химийн хорт болон аюултай бодист хяналт, шалгалт хийх заавар боловсруулна.<br>2.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмын холбогдох саналыг өгч тусгуулна. | ***<u>Эхний хагас жил:</u>***<br>1.Ажлын хэсгийн хүрээнд хяналт, шалгалтын зааврын бүтцийг боловсруулахад оролцож санал өгсөн ба Химийн хорт болон аюултай бодист хяналт, шалгалт хийх 7 зааврыг төслийг боловсруулсан. | 2024.01.02-2024.06.05 | 98 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллаж холбогдох саналыг тусгуулсан.<br><br>-Гаалийн тухай хуулийн төсөлд химийн хорт болон аюултай бодисын хяналтын чиглэлээр хууль тогтоомжийн судалгаа, санал хүргүүлсэн.<br><br>-Гаалийн тухай хуулийн төсөлд тусгуулах гаалийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлийг тусгуулах чиглэлээр хэлэлцүүлэгт оролцож холбогдох саналуудыг тусгуулсан.<br><br>-Гаалийн хяналт шалгалтын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 28 дугаар дотоод зурвасаар Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журамд санал хүргүүлсэн.<br><br>-Хяналтын нэгдсэн төвийн үйл ажиллагааны зааварт ХНТ-д 2023.03.15-ны өдрийн 56 дугаар дотоод зурвасаар санал хүргүүлсэн.<br><br>-Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ХХ-т | 3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана. | 2. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмын төсөлд холбогдох саналыг өгч тусгуулж ажилласан.<br><br>3. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн санал хүргүүлэх тухай албан бичгээр химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам болон Химийн хорт болон аюултай бодис хадгалах, ашиглах, устгах журамд тус тус санал хүргүүлсэн<br><br>"Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах журам"-ын Пиротехникийн хэрэгслийг импортлохтой холбоотой 2 заалтыг тусгуулахаар ХБГ-т хүргүүлсэн.<br><br>Зөрчилтэй тэмцэх газарт 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 198 дугаар дотоод зурвасаар "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүний худалдаанд хяналт тавих тухай" хуулийн төсөлд нийт 6 саналыг хүргүүлсэн.<br><br>Хуулийн хэлтэст "Бүтээгдэхүүнийг тохирлын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2023.03.17-ны өдрийн 58 дугаар дотоод зурвасаар санал хүргүүлсэн.<br><br>-СХЗГ-ын Төмөрлөгийн стандартчиллын техникийн хороо /ТХ21/-нд Төмөр бүтээцийн ган туйван MNS JIS G 3112:2002 стандартын төсөлд санал хүргүүлсэн.<br><br>-Гаалийн улсын байцаагчийн гаалийн байгууллагын нэгж хооронд шилжүүлэн ажиллах журмын төсөлд 2023 оны 05 сарын 08-ны өдрийн 125 тоот дотоод зурвасаар Хүний нөөцийн хэлтэст санал хүргүүлэв.<br><br>-"Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-ыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан чанарын тохирлын хяналтын чиглэлээр лабораторийн шинжилгээнд хамрагдах химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг шинэчилж өгсөн. | | баталгаатайгаар зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам" болон "Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт"-ын төсөлд өгөх 9 заалт бүхий саналыг боловсруулж 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 12 дугаар дотоод зурвасыг хүргүүлсэн.<br><br>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн "Химийн бодисын ашиглалт, хадгалалт, аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах талаар авах хариу арга хэмжээний тухай үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилт" хэлэлцүүлэгт 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр оролцож, тус хэлэлцүүлгээс чиглэл өгөгдсний дагуу Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах 19 саналыг үндэслэлийн хамт гаргаж ҮАБЗ-ийн референт Ш.Энхзулд емайл хаягаар хүргүүлсэн.<br><br>Хуульд заасны дагуу Химийн хорт болон аюултай бодисын 2023 оны жилийн эцэс болон 2024 оны 1, 2 дугаар улирал, хагас жилийн мэдээг гаргаж БОАЖЯ-нд, Бордоо, ургамал | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамгааллын бодисын мэдээг ХХААХҮЯ-нд тус тус хүргүүлсэн | | |
| 3. | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1 болон 2. Хорио цээрийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, гаалийн хяналт, шалгалтын эрсдэлийн шалгуур, программтай хэрхэн уялдуулах талаар санал<br>боловсруулж ХЦХ-ийн ажилтнуудад болон<br>ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан.<br>Мөн хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад эрсдэл тооцох үйл ажиллагааг Гаалийн хяналт, шалгалтын эрсдэлийн удирдлагын модультай уялдуулах хувилбарыг боловсруулж танилцуулсан.<br><br>3.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах барааг шалгахад анхаарах асуудал (эрсдэлийн анхааруулга)-ыг БТКУС-ийн 8 орны түвшинд кодлогдсон бараа тус бүрээр боловсруулан нэгтгэж | 1.Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг ЭУХ-тэй хамтран боловсруулж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгоход санал өгнө.<br>2.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад эрсдэл тооцох шалгуур, үзүүлэлтийг боловсруулж ЭУХ-т хүргүүлнэ.<br>3.ЭУХ болон газар, хороодоос ирүүлсэн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг судалж санал боловсруулж хүргүүлэх | ***Эхний хагас жил***: 1 болон 2. Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэх журмыг төсөлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлээр тусгуулах саналыг 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 77 дугаар дотоод зурвасаар хүргүүлж, тус саналыг хэлэлцэх хурлыг Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ажилтнуудтай 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр хийж журамд тусгах асуудлаар санал нэгдсэн<br><br>3. ЭУХ-т 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 42 дугаар дотоод зурвасаар УБГГ-аас эрсдэлийн дүн шинжилгээ хийж ирүүлсэн аж ахуйн нэгжийг "Зөвшөөрөгдсөн шалгуур"-т оруулах эсэх асуудлаар санал хүргүүлсэн.<br>Эрсдэлийн удирдлагын хэлтэст 2024 оны 02 дугаар сарын 22-ны 57 дугаар дотоод зурвасаар өвөлжилт, хаврын нөхцөл, байдал хүндэрсэнтэй холбогдуулан зарим барааг зөвшөөрөгдсөн шалгуурт оруулах асуудлаар санал хүргүүлсэн. | 2024.01.02-2024.06.05 | 98 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 206 дугаар дотоод зурвасаар Эрсдэлийн удирдлагын хэлтэст хүргүүлсэн.<br><br>4. Пестицид импортлогч нар болон шуудангийн үйлчилгээ эрхлэгч нарт зориулсан сургалтад химийн хорт болон аюултай бодисын импортод тавигдах шаардлага сэдвээр мэдээлэл бэлтгэн танилцуулсан.<br><br>Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан "Экспорт, импортын зөвшөөрөл олгох, хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын мэдээллийг цахимжуулах-гарц, шийдэл" сэдэвт хэлэлцүүлэгт Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас төлөөлөл оролцуулж иргэд, ААНБ, ГУБ нарт мэдээлэл өгүүлсэн. | 4.Химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэхтэй холбоотой хууль тогтоомж, стандартын шаардлагыг ил тод, нээлттэй байршуулж гадаад худалдаа эрхлэгчдийг мэдээллээр хангана. | Эрсдэлийн удирдлагын хэлтэст 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 130 дугаар дотоод зурвасаар Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлтийг хүргүүлсэн.<br><br>4. Химийн хорт болон аюултай бодисын хяналтын чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас асуудаг түгээмэл асуулт, хариулт 5-ийг боловсруулж хүргүүлсэн.<br><br>Аюултай хог хаягдал экспортлоход тавигдах шаардлага сэдэвт постер болон зөвлөмжийг боловсруулж Монголын гааль фэйсбүүк хуудсанд 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр байршуулсан.<br><br>Химийн хорт болон аюултай бодисын ангилал сэдвээр постер бэлтгэн Монголын гааль фэйсбүүк хуудсанд 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр байршуулсан.<br><br>Аюултай ачаа тээвэрлэхэд тавигдах шаардлага сэдэвт постерыг боловсруулж бэлтгэн Монголын гааль фэйсбүүк хуудсанд байршуулахаар өгсөн.<br><br>***<u>Сүүлийн хагас жил:</u>*** 1.Гаалийн автоматжуулсан системийн "Шалгалтын үр дүн"-гийн саналд 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 08 дугаар сарын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 27-ны байдлаар дүн шинжилгээ хийж танилцуулгыг бичсэн.<br>2.Гаалийн автоматжуулсан системийн "Шалгалтын үр дүн"-гийн санал дүн шинжилгээ хийх ажлыг 2024 оны эхний 9 сарын байдлаар шинэчлэн боловсруулж танилцуулгыг бичиж удирдлагад танилцуулсан.<br><br>3. ХЦХ-т 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн №2024/183 дугаар дотоод зурвасаар дараах чиглэлийг хүргүүлсэн. Үүнд:<br>-Дүн шинжилгээ хийхэд тогтоогдсон асуудал,<br>-Хорио цээрийн хяналт хариуцсан ГУБ нарын "Шалгалтын үр дүнгийн санал"-ын код, ангиллыг бичиг баримтын болон хяналт шалгалт хариуцсан ГУБ нарын "Шалгалтын үр дүнгийн санал"-ын код, ангилалтай ижилсгэх санал боловсруулж ирүүлэх<br>-Харъяа гаалийн газар, хороодын хорио цээрийн хяналт хариуцсан ГУБ нарт Шалгалтын үр дүнгийн санал бичих асуудлаар зөвлөмж өгөх<br><br>4.ХЦХ-ээс холбогдох саналыг дотоод зурвасаар авч 2024 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 2024/205 дугаар дотоод | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зурвасаар Эрсдэлийн шалгуурын судалгааны “Шалгалтын үр дүнгийн санал”-д нэмэлт, өөрчлөлт оруулах программын дараах даалгаврыг хүргүүлсэн.<br>5. Харъяа гаалийн газар, хороодоос “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт” ирүүлсний дагуу дүн шинжилгээ, судалгаа хийж 18 хяналтын хуудас, эрсдэлийн түүхийг боловсруулж баталгаажуулсан.<br>6. Говь ХК, АПУ ХК, ХАНБОГД КАШИМЕР ХХК-д гаалийн итгэмжлэл олгох шалгуурыг үнэлэх, баталгаажуулах ажлын удирдамжийн дагуу ажлын хэсэгт ажиллаж ажлын байранд нь очиж үнэлгээ, баталгаажуулалт хийх, “Дотоод хяналтын шалгуур” хэсгийн тайланг боловсруулах, бусад шалгуурын тайланг нэгтгэж Нэгдсэн тайлан бичих зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.<br><br>ХЦХ болон ГТЛ-д 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 2024/169, 2024/171 дугаар дотоод зурвасыг хүргүүлж, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалттай холбоотой саналыг авсан. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрсдэлийг таньж тогтоох, дүн шинжилгээ хийх, бууруулах чиглэлээр судлаж өөрийн мэдлэгийг дээшлүүлсэн байна. | ***Эхний хагас жил:***<br>1.Байгууллагын эрсдэл гэж юу болох, байгууллагын эрсдэлд хамаарах асуудлын талаар судалсан.<br>2. Хорио цээрийн хэлтсийн эрсдэлийг таньж тогтоохын тулд хэлтсийн нийт албан хаагчдаас дараах чиглэлийн асуумжийг авч нэгтгэн дүгнэсэн. Үүнд:<br>Байгууллагын соёл-26<br>Удирдлагын манлайлал-25<br>Ажлын байранд нөлөөлөх физик, хими, биологийн хүчин зүйл -4<br>Ажилчдын эрүүл мэндийн эрсдэл-12<br>Ажлын байр болон ажилчид хоорондын харилцаа, нийгмийн хангамжийн сэтгэл ханамж -28 | 2024.01.02-2024.06.05 | 95 % |
| **Зорилт 2. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"** | | | | | | | |
| 5. | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын чиглэлээр дэд бүтцийг чадавхжуулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Ажлын хэсгийн гишүүд Интерактив ХХК-ийн ажилтнуудтай хамтран Хяналт шалгалтын модулийн /AS-IS/ болон ирээдүйн үйл ажиллагааны To-Be загвар, системийн шаардлагыг эцэслэн боловсруулах ажлыг гүйцэтгэсэн. (экспорт, импорт, транзит, хилээс гүн рүү шилжүүлэх, гүнээс хил рүү шилжүүлэх, ТИР гэх мэт) | 1.Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах төслийн хүрээнд "Хилийн хяналт удирдлагын систем"-ийг Гаалийн автоматжуулсан удирдлагын системтэй уялдуулан хөгжүүлэх ажлын хэсэгт ажиллаж | ***Эхний хагас жил***: 1. Ажлын хэсгийн төлөвлөгөөтэй холбогдуулан химийн хорт болон аюултай бодисын хяналтад хамрагдах барааг HS кодтой уялдуулан зориулалтаар нь ангилах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Химийн хорт болон аюултай бодисын чиглэлээр төрийн ямар байгууллагатай мэдээлэл солилцох, ямар мэдээллийг солилцох талаар судалгаа гаргасан. | 2024.01.02-2024.06.05 | 95 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажилтай холбогдуулан химийн хорт болон аюултай бодист хяналт шалгалт хийх нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр санал өгч ажилласан. | холбогдох ажлыг хийж гүйцэтгэх<br>2. Бусад газар, хэлтсээс боомтын төлөвлөлттэй холбоотой асуудлаар санал авахаар ирүүлсэн тохиолдолд химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүнд хийгдэх хяналт шалгалтыг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, сайжруулах чиглэлээр санал боловсруулж хүргүүлнэ. | Химийн хорт болон аюултай бодисын ерөнхий ангилал, нэр төрлөөр нь багцлан ангилах, зориулалтаар нь ангилах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>2.-Бичигтийн боомтын хорио цээрийн хяналт шалгалтад ашиглагдах шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, материалын жагсаалтад "Химийн хорт болон аюултай бодисын найрлага тодорхойлох багаж", "Химийн бодист хяналт шалгалт хийх улсын байцаагчийн ажлын цүнх болон дээж авах, анхан шатны үзлэг хийхэд туслах багаж хэрэгслүүд", "Химийн бодисын асгаралтыг цэвэрлэх иж бүрдэл", "Асбестийн агууламж тодорхойлох багаж" зэрэг багаж, тоног төхөөрөмжийг тусгуулахаар санал өгсөн.<br>-Байгууллагын 2025 оны төсвийн төсөөлөлд химийн хорт болон аюултай бодис нэвтрүүлэх 7 боомтод Химийн хорт болон аюултай бодисын хяналт, шалгалт хийхэд ашиглах багаж, хэрэгслийн нэр төрөл, үнийн судалгааг гаргаж төсвийн төсөөлөлд тусгуулсан. | | |
| 6. | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Харъяа газар, хороодыг гаалийн улсын байцаагч нарын химийн хорт болон аюултай бодис, химийн | 1.Улсын хилээр нэвтрүүлж буй хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын | ***Эхний хагас жил***: 1. Замын-Үүд ГГ-т 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн чиглэл хүргүүлэх тухай албан бичгийг хүргүүлж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тохирлын хяналт,шалгалт хийсэн байдал | | үйлдвэрийн бүтээгдэхүүнтэй холбоотой илрүүлсэн зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхэд мэргэжил, аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллаж байна.<br><br>ТАЗ болон АТГ-аас ГЕГ-т зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдуулан хилийн мэргэжлийн хяналтын байгууллага, гаалийн байгууллагатай нэгдсэнтэй холбогдуулан шийдвэрлэх шаардлагатай асуудлын талаарх танилцуулгыг бэлтгэж хүргүүлсэн. | хяналтад хамрагдах бараанд хийх эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулж, харьяа гаалийн газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар ханган хяналт тавина. | аюултай хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх талаар Замын-Үүд ГГ-тай хамтран ажиллаж холбогдох асуудлыг шийдвэрлэсэн.<br><br>Харъяа гаалийн газар, хороодод 2024 оны 06 дугаар сарын 14-ний 02-1.2/2449 дугаар албан бичгээр хураагдсан химийн бодисыг тухай бүр нь Засаг даргын дэргэдэх захиргааны зөвлөлд шилжүүлэх, саатуулах тохиолдолд хадгалалтын горимыг баримтлах тухай чиглэлийг хүргүүлсэн.<br><br>Эм биобэлдмэл, химийн бодисын хяналтыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд сэдэвт сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд хамтран зохион байгуулж газар, хороодын химийн хорт болон аюултай бодисын хяналт хариуцсан 18 ГУБ-ыг хамруулсан | 2024.01.02-2024.06.05 | 98 % |
| | | | 2. Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр баталсан "Нийслэл, орон нутгийн зарим гаалийн газар, хороодын үйл ажиллагаатай танилцаж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт 2023 оны 03 | 2.Бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх үйл ажиллагааг ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын үйл | 2. Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журмын төсөлд 5 заалт бүхий саналыг боловсруулж 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 431 дугаар дотоод зурвасаар хүргүүлсэн.<br><br>-Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх зааврын төсөлд 10 заалт бүхий саналыг боловсруулж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дугаар сарын 03-наас УБГГ-т ажиллаж хийсэн ажлын товч тайлан, дэлгэрэнгүй тайлан, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж ажлын хэсэгт хүргүүлсэн.<br><br>Мөн Мэдээллийн технологийн газарт гаалийн хорио цээрийн чиглэлийн газар, хороодын хяналт, шалгалтын тайлан, лабораторийн тайлан, хорио цээрийн ГУБ тайланг Гаалийн автоматжуулсан удирдлагын системээр нэгтгэдэг болгох, одоо байгаа тайланд нэмэлт өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох талаар мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн.<br><br>4.Химийн хорт болон аюултай бодис, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүний асуудлаар БОАЖЯ-наас байгуулсан 3, ЭМЯ-наас байгуулсан 1 ажлын хэсэгт хэсэгт ажиллаж төрийн байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж | ажиллагаатай уялдуулна.<br><br>3.Хяналт, шалгалтын үйл ажиллагаа, тайлан, мэдээнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 432 дугаар дотоод зурвасаар хүргүүлсэн.<br><br>-Барааг буцаах, устгах зааврын төсөлд 12 саналыг боловсруулж өгсөн.<br><br>-“Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-д 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 173 дугаар дотоод зурвасаар 38 заалт бүхий санал хүргүүлэв<br><br>-Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын заавар боловсруулах аргачлалыг боловсруулж ГЕГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Дотооддоо мөрдөх заавар боловсруулах аргачлал, жагсаалт, загвар батлах тухай” А/380 дугаар тушаалаар батлуулсан.<br><br>3. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа, тайлан, мэдээнд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлын талаар газар, хороодын хорио цээрийн хяналт хариуцсан ГУБ нартай хийсэн цахим уулзалтад танилцуулсан.<br><br>4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллах, шаардлагатай асуудлыг бодлого шийдвэрт тусгуулсан. | 4.Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох яам, агентлагаас зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт оролцож, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллана. | А/181 дүгээр тушаалаар байгуулагдсан Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам болон Химийн хорт болон аюултай бодис хадгалах, ашиглах, устгах журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажиллаж Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн санал хүргүүлэх тухай албан бичгээр саналыг хүргүүлж журмын төсөлд тусгуулсан.<br><br>Монгол Улсын Засгийн газрын газраас холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах чиглэл өгөгдсний дагуу Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, **Хог хаягдлын тухай хууль,** Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, хийдэл үүсгэж буй асуудал, өөрчлөлт оруулах саналыг холбогдох тайлбарын хамт гарган өгсөн.<br><br>Хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хурлаар 9 аж ахуйн нэгжид аюултай хог | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаягдал дахин боловсруулах чиглэлээр зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хэлэлцэхэд оролцсон. | | |
| 7. | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангасан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Улсын хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсээр химийн хорт болон аюултай бодисыг нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалтыг хийж ажилласан. Химийн бодистой холбоотой осол, аюул гараагүй. | 1.Хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсэд химийн осол, аюул гарахаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангана.<br><br>2.Харъяа газар, хороодын хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсэд химийн осол, аюул гарахаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэн тайлагнаж удирдлагыг мэдээллээр хангана. | ***Эхний хагас жил***: 1.Харъяа гаалийн газар, хороодод 2024 оны 06 дугаар сарын 14-ний 02-1.2/2450 дугаар албан бичгээр хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсэд химийн осол, аюул гарахаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг чиглэлээр хэрэгжүүлсэн ажлыг тайлагнах, цаашид анхаарах асуудлын талаар чиглэл хүргүүлсэн.<br><br>2. ЧХОУНБ дахь ГГ-аас “Химийн хорт болон аюултай бодис, эм биобэлдмэлд тавигдах хорио цээрийн хяналт” сэдэвт сургалтыг газрын даргын баталсан хөтөлбөрийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 29-нд нийт15 гаалийн бүртгэгдсэн болон зуучлалын мэргэжилтнийг оролцуулан сургалт зохион байгуулсан.<br><br>Сэлэнгэ ГГ-аас Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн тавих хяналт шалгалтыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хорио цээр | 2024.01.02-2024.06.05 | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | албанаас "Chemistry" сарын аяныг 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 3 дугаар сарын 31-ний хооронд зохион байгуулж 18 бүртгэгдсэн мэргэжилтэнд гарын авлага тараах, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд химийн хорт болон аюултай бодис асгаралтын үед, хариу арга хэмжээ авахад хэрэглэх хувцас хэрэгсэл захиалгыг санхүү аж ахуй албанд гарган өгөх, хураагдсан химийн бодисыг Элемент ХХК-д шилжүүлэх, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын нийт 57 албан хаагчдад "Химийн хорт болон аюултай бодисын хяналт, дээж авах аргачлал" сэдэвт сургалтыг зохион байгуулах, Тактикийн дадлага сургуулилтын бэлтгэл ажлын хүрээнд 8 багт хуваагдан ширээний дасгал сургуулилт хийх зэрэг ажлыг тус тус зохион байгуулсан байна. | | |
| 8. | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд тавьсан хяналт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 2023 оны 06 дугаар сарын 16-ны байдлаар импортын 2615, экспортын 29 дээжийг БТКУС код тодорхойлох лабораторийн шинжилгээнд хамруулснаас ангиллын код зөрсөн 16, БОАЖЯ- | 1.Хяналтын чиглэл бүрээр лабораторийн шинжилгээнд хамрагдсан барааны тоо хэмжээ, үзүүлэлтийн тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн, удирдлагуудыг мэдээллээр хангана. | ***Эхний хагас жил***: 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2023 оны 06 дугаар сарын 17-ны байдлаар импортын 2076, экспортын 12 дээжийг БТКУС код тодорхойлох лабораторийн шинжилгээнд хамруулснаас ангиллын код зөрсөн 126, БОАЖЯ-наас тусгай зөвшөөрөл авах шаардлагатай 2, стандартын шаардлага | 2024.01.02-2024.06.05 | 95 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | наас тусгай зөвшөөрөл авах шаардлагатай 16, гадаад худалдааны дагалдах баримт бичиг бараанаас зөрүүтэй 1 зөрчил тус тус илэрсэн байна. | 2.Лабораторийн шинжилгээгээр зөрэг буюу шаардлага хангаагүй гарсан барааны дүнд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэлтэд хяналт тавина. Энэ чиглэлээр харьяа гаалийн газар, хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана. | хангаагүй /дизель түлш/ 2 зөрчил тус тус илэрсэн байна. | | |
| 9. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | -ГХЦГ-ын 2022 оны жилийн эцсийн тайлангийн танилцуулга болон ГЕГ-ын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Гаалийн хорио цээрийн хэлтсээс тусгуулах төлөвлөгөөний төслийг боловсруулав.<br>- Гаалийн ерөнхий газрын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлт, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг гаргаж хүргүүлсэн. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллан тайлагнана. | ***<u>Эхний хагас жил</u>***: -Сургалтын төвд Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлээр ажиллаж буй албан хаагчдаас эрдмийн зэрэг, цол хамгаалсан, удахгүй эрдмийн зэрэг цол хамгаалах (судалгааны ажил хийж буй) албан хаагчдын судалгааг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 82 дугаар дотоод зурвасаар хүргүүлсэн<br>-Хяналт, бүрдүүлэлтийн газарт 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар дотоод зурвасаар үйлдвэрлэлийн технологийн хүнд даацын тээврийн хэрэгслийн талаар ирүүлсэн албан бичигтэй холбоотой санал хүргүүлсэн<br>-Химийн хорт болон аюултай бодисын хяналт хариуцсан ГУБ-ын ажлын байрны | 2024.01.02-2024.06.05 | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -ГЕГ-ын удирдлага солигдсонтой холбогдуулан хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлийн танилцуулгыг бэлтгэж удирдлагад өгөв.<br>-ГЕГ-ын бүтэц, зохион байгуулалт шинэчлэн зохион байгуулах ажлын хэсэг батлагдсантай холбогдуулан ГХЦГ-ын чиг үүргийг боловсруулан удирдлагад өгөв.<br>-Ерөнхий сайдад танилцуулах видео танилцуулгад орох ГХЦГ-ийн текстийг боловсруулсан.<br>-ГЕГ-ын Хорио цээрийн хэлтсийн Химийн хорт болон аюултай бодисын хяналт хариуцсан ГУБ болон газар, хороодын Химийн хорт болон аюултай бодисын хяналт хариуцсан ГУБ-ын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан.<br>-Хяналт, бүрдүүлэлтийн газарт гаалийн байгууллагын цахимжуулалтын төлөвлөгөөнд хорио | | тодорхойлолтыг боловсруулж хүргүүлсэн<br>-Захиргааны удирдлагын газарт нийт албан хаагчдад зориулсан “Мэдээллийн цаг”-аар Хорио цээрийн хэлтсээс мэдээлэл өгөх сэдвийн тухай саналыг 2024 оны 01 сарын 08-ны өдрийн 08 дугаар дотоод зурвас хүргүүлсэн.<br>-Сургалтын төвд 2024 оны сургалтын төлөвлөгөөнд хүргүүлэх саналыг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 10 дугаар дотоод зурвасыг хүргүүлсэн.<br>-Хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийх ажлын саналыг боловсруулж хүргүүлсэн.<br>-Хуулийн хэлтэст 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 448 дугаар дотоод зурвасаар хорио цээрийн хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүрэгт хамаарах “хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй” 2 тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан, цаашид авах арга хэмжээний саналыг хүргүүлсэн.<br>-Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст 2023 оны 01 дүгээр 03-ны өдрийн 05 дугаар дотоод зурвасаар хорио цээрийн хэлтсийн үйл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цээрийн хэлтсээс тусгуулах саналыг хүргүүлсэн.<br><br>-Хяналт, бүрдүүлэлтийн газарт гаалийн байгууллагын цахимжуулалтын төлөвлөгөөнд хорио цээрийн хэлтсээс тусгуулах саналыг хүргүүлсэн.<br><br>-Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт химийн хорт болон аюултай бодисын хяналтын чиг үүрэг, цаашдын бодлогын асуудлын талаар танилцуулга бичиж хүргүүлсэн.<br><br>- ХШҮДАГ-т чиг үүрэгт хамааралтай МУ-ын хууль, ЗГ-ын тогтоол, яамдын сайдын тушаалаар батлагдсан дүрэм, журмын жагсаалт, дотоод аудитад хамруулах шаардлагатай ажил, үйлчилгээний талаарх мэдээллийг хүргүүлсэн.<br><br>-Гаалийн байгууллагын 2023 оны эхний хагас жилийн тайланд оруулах ажлын танилцуулгыг | | ажиллагаанд хийгдсэн дотоод аудитын зөвлөмжөөр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлтийг гаргаж хүргүүлсэн<br><br>-Сургалтын төвд 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 121 дугаар дотоод зурвасаар сургагч багш нарын болон нэмэлтээр хяналтын чиглэл тус бүрээр хичээл заах сургагч багш нарын мэдээлэл, хичээл заах сэдэв, холбогдох саналыг сургалтын төвд хүргүүлсэн.<br><br>***<u>Сүүлийн хагас жил</u>:*** ГЕГ-ын бүтцийн нэгжийн газар, хэлтэст нийт 18 дотоод зурвасыг боловсруулж хүргүүлсэн.<br><br>Харьяа гаалийн газар, хороод болон бусад байгууллагаас ирүүлсэн 8 албан бичгийг хүлээн авч, 5 албан бичгийг боловсруулан хүргүүлсэн.<br><br>ГЕГ-ын ЗББНДБ болон харъяа гаалийн газар хороодын албан хаагчдыг оролцуулан 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх онол, практикийн асуудал" сэдэвт уулзалт, сургалтын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулахад оролцсон.<br><br>ГЕГ-ын ЗББНДБ болон харъяа гаалийн газар хороодын нийт 100 гаруй албан хаагчдыг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бэлтгэж Хяналт, бүрдүүлэлтийн газарт хүргүүлсэн.<br>-ХШҮДАГ-т дараах мэдээллийг гарган өгсөн. Үүнд:<br>Химийн хорт болон аюултай бодисын хяналт хариуцсан губ нарын чиг үүрэг, химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа, тавигдах шаардлагууд, химийн хорт болон аюултай бодисын хяналтын чиглэлээр хийгдсэн голлох ажлууд, хууль тогтоомжийн жагсаалтуудыг гарган өгсөн.<br>Гаалийн хорио цээрийн хяналтад хамрагдах барааны жагсаалтыг CAIS системд оруулсан талаар танилцуулга<br>ГЕГ-ын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн а/20 дугаар ажлын хэсэгт ажиллаж хэрэгжүүлсэн ажлын тухай тайлан<br>ГЕГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн а/92 дугаар тушаалаар байгуулагдсан | | оролцуулан 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан Гаалийн ёс зүйн чиг хандлага, хөгжил сэдэвт уулзалт, сургалтын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулахад оролцсон.<br>Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодын 50 гаруй (30 албан хаагч танхимаар, 20 гаруй албан хаагч цахимаар) албан хаагчдыг оролцуулан 2024 оны 11 дүгээр сарын 05-06 өдрүүдэд зохион байгуулсан сургалтын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулахад оролцсон.<br>“Эрсдэлийн удирдлагын систем болон барааг сонгон шалгах үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төсөл” (2025-2027)-ийг хэрэгжүүлэх БНСУ-ын КОИКА байгууллагын техник эдийн засгийн судалгаа хийх багтай 2024 оны 11 дүгээр сарын 24-нөөс 30-ныг хүртэл хийх уулзалтын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулахад оролцсон.<br>Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгийн “Худалдаан дахь техникийн саад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажлын хэсгийн хийсэн ажлын тайлан<br>Хорио цээрийн хэлтсээс 2022 онд хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр хийгдсэн ажлын тайлан<br>-ХШҮДАГ-т 2023 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн 138 дугаар дотоод зурвасаар чиг үүрэгт хамааралтай МУ-ын хууль, ЗГ-ын тогтоол, яамдын сайдын тушаалаар батлагдсан дүрэм, журмын жагсаалт, дотоод аудитад хамруулах шаардлагатай ажил, үйлчилгээний талаарх мэдээллийг хүргүүлсэн.<br>-Гаалийн байгууллагын 2023 оны эхний хагас жилийн тайланд оруулах ажлын танилцуулгыг бэлтгэж Хяналт, бүрдүүлэлтийн газарт хүргүүлсэн. | | тотгор” бүлэгт ажиллаж Гурав болон дөрөвдүгээр шатны хэлэлцээний хуралд оролцсон.<br>Гаалийн захиргаа дотоод ажлын системээр өгөгддөг “Үүрэг, даалгавар” хэсгийг хариуцан ажиллаж, үүрэг, даалгаврыг оруулах, биелэлтэд хяналт тавих, дүгнэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. | | |
| 10. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн хүрээнд Сэлэнгэ аймаг болон Замын-Үүд | 1. ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, | ***<u>Эхний хагас жил</u>***: Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн хүрээнд “Хилийн зохицуулалттай менежментийг хэрэгжүүлэх нь сэдэвт Хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | суманд хил, хяналтын байгууллагын ажилтан нарт 2023 оны 06 сард зохион байгуулсан сургалтад сургагч багшаар оролцож Хорио цээрийн хяналтын онцлог сэдвээр илтгэл бэлтгэн танилцуулсан. | удирдлага арга зүйгээр хангана.<br>2. Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээнд оролцож, төрийн болон төрийн бус байгууллага, гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллана. | гарын авлагын “Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт” сэдвийн хөтөлбөр, агуулгыг боловсруулж, номын нээлтийн үйл ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хийсэн. Уг сэдвийн агуулгад орсон олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомж, ЗГ, хяналтын байгууллага хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээр, протокол, санамж бичгийг веб сайтад байршуулж номонд Qr код болон link-ийг оруулан ГУБ нар мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.<br><br>Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтын нийт 4 ангид “Химийн хорт блон аюултай бодист тавих хяналт шалгалт” сэдвээр 45 минутийн лекц, семинарын материал бэлтгэн суралцагчдад танилцуулсан. | 2024.01.02-2024.06.05 | 100 % |
| 11. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Ажлын цаг ашиглалтыг 100 хувь хангаж ажилласан. | 1. Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.<br>2. Нэгжийн ажлын цаг ашиглалтын оноо суурь түвшнээс буураагүй байна. | ***Эхний хагас жил***: Ажлын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулж ажилласан.<br><br>***Сүүлийн хагас жил:*** Эрсдэлийн удирдлагын хэлтэст 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр шилжин ирсэн нийт 82 хүн/өдөр буюу 656 цаг ажиллахаас 82 хүн/өдөр буюу 656 цаг ажилласан. Тасалсан, өвчтэй, чөлөөтэй өдөр байхгүй болно. | 2024.01.02-2024.06.05 | 100 % |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12. | Үүрэг даалгавар 1. ГЕГ болон Худалдан авах ажиллагааны газраас хамтран зохион байгуулсан худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Энэ сургалтад хамрагдаж байгаагүй. | Сургалтад хамрагдаж шалгалт өгөн тэнцсэн байна. | ***Эхний хагас жил***: Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад 2024 оны 05 дугаар сарын 14-ны өдрөөс 05 сарын 16-ны хооронд сургалтад хамрагдаж 05 сарын 17-нд шалгалт өгч тэнцсэн. | 2024.05.14-2024.05.17 | 100 % |
| 13. | Үүрэг даалгавар 1. Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ирсэн, явсан бичиг, дотоод зурвасын бүртгэл хөтлөх, цохуулах, шийдвэрлэх ГУБ нарт шилжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хэлтсийн ирсэн, явсан бичиг, дотоод зурвасын бүртгэл хөтлөх, цохуулж ГУАБ, ГУБ нарт шуурхай шилжүүлэн ажилласан байна. | ***Сүүлийн хагас жил:*** -Ирсэн 81 дотоод зурвасыг бүртгэн цохуулж, холбогдох ГУАБ, ГУБ-д шилжүүлж ажилласан.<br>-Явсан 75 дотоод зурваст дугаар олгон бүртгэл хөтөлсөн.<br>-Ирсэн 57 бичгийг хүлээн авч бүртгэл хөтлөн цохуулж шийдвэрлэх ГУАБ, ГУБ нарт цахимаар болон цаасаар шилжүүлж ажилласан.<br>-Явсан 18 бичгийг явсан бичгийн дэвтэрт бүртгэж ажилласан. | 2024.08.20-2024.12.31 | 100 % |
| 14 | Үүрэг даалгавар 2. Хэлтсийн 7 хоногийн тайлан, төлөвлөгөө гаргах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хэлтсийн 7 хоногийн тайлан, төлөвлөгөөг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна. | ***Сүүлийн хагас жил:*** Эрсдэлийн удирдлагын хэлтсийн нийт 15 долоо хоногийн төлөвлөгөө, тайланг гарган Хяналт, бүрдүүлэлтийн газарт хүргүүлж ажилласан. | 2024.08.20-2024.12.31 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 13. | Арга хэмжээ 1. Багшлах эрхийн сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслөөс зохион байгуулах сургагч багшийн 3 өдрийн сургалтад 2023 оны 01 сарын 25-ны өдрөөс 2023 оны 01 сарын 27-ны өдрүүдэд хамрагдаж сургагч багшийн гэрчилгээ авсан. | Багшлах эрхийн сургалтад хамрагдсан байна. | ***<u>Эхний хагас жил</u>***: ГЕГ-ын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Боловсролын их сургуулийн Боловсрол судлалын сургуулийн Багшлах эрхийн сертификатын 45 хоногийн сургалтад хамрагдаж 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр дадлага ажлыг хамгаалж тус сургалтын амжилттай дүүргэв. | 2024.04.10-2024.05.22 | 100% |
| 14. | Арга хэмжээ 2. Байгууллагаас болон бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдаж өөрийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн хорио цээрийн ажилтнуудад гаалийн хэргийн мэдлэг олгох 3 өдрийн сургалтад 2023 оны 03 сарын 01-ний өдрөөс 2023 оны 03 сарын 03-ны өдрүүдэд хамрагдаж гаалийн хэргийн мэдлэгийг дээшлүүлж сертификат авсан. | Холбогдох сургалтад хамрагдсан байна. | ***<u>Эхний хагас жил</u>***: Эрчим хүчний зохицуулах хороо, АНУ-ын Хөгжлийн агентлагаас Монголын эрчим хүчний засаглал хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 22-ноос 26-ны хооронд зохион байгуулсан Эрчим хүчний үр ашгийн стандартууд, шошгожуулалт сэдэвт 5 хоногийн сургалтад оролцсон.<br>ГЕГ-аас 14 хоног тутам зохион байгуулдаг | 2024.01.02-2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Мэдээллийн цаг"-т тогтмол хамрагдаж байна. | | |
| 13. | Арга хэмжээ 1. Хэлтсийн чиг үүрэг болон олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийг судлах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн хяналтад эрсдэл тооцох чиглэлээр мөрдөгдөж буй Олон улсын гэрээ, конвенц, стандарт, Үндэсний хууль тогтоомжийг судалсан байна. | ***<u>Сүүлийн хагас жил:</u>*** Эрсдэлийн удирдлагын компендиум, ДГБ-ын Аюулгүй байдлын багц стандарт, ГЕГ-ын даргын 2021 оны А/118 тушаалаар батлагдсан "Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам" зэрэг холбогдох баримт бичгийг судалсан.<br>Удирдлагын академиас зохион байгуулсан Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах сургалтад 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хамрагдаж өөрийн мэдлэгийг дээшлүүлсэн. | 2024.08.20-2024.12.31 | 95% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Гаалийн улсын байцаагч .................................................. / Н.Энхтайван/ 2024.12.12

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Н.ЭНХТАЙВАНЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Эрсдэлийн удирдлагын хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. "ОЛОН УЛСЫН ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ, ТҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 56 | 10 | 66 | |
| 2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 54 | 8 | 62 | |
| 3 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлсэн байдал | 55 | 8 | 63 | |
| 4 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 57 | 10 | 67 | |
| **Зорилт 2. "ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ "-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын чиглэлээр дэд бүтцийг чадавхжуулсан байдал | 55 | 10 | 65 | |
| 2 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт,шалгалт хийсэн байдал | 57 | 10 | 67 | |
| 3 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангасан байдал | 57 | 10 | 67 | |
| 4 | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд тавьсан хяналт | 55 | 10 | 65 | |
| 5 | Үүрэг даалгаврын биелэлт | 57 | 10 | 67 | |
| 6 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 57 | 10 | 67 | |
| **Зорилт 3. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" -ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| | Ажлын цаг ашиглалт | 57 | 10 | 67 | |

| Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | ГЕГ болон Худалдан авах ажиллагааны газраас хамтран зохион байгуулсан худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдах | 55.1 | 10 | 65.1 | |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1 Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ирсэн, явсан бичиг, дотоод зурвасын бүртгэл хөтлөх, цохуулах, шийдвэрлэх ГУБ нарт шилжүүлэх | 55.1 | 10 | 65.2 | |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2 Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ирсэн, явсан бичиг, дотоод зурвасын бүртгэл хөтлөх, цохуулах, шийдвэрлэх ГУБ нарт шилжүүлэх | 55.1 | 10 | 65.1 | |
| **Дундаж оноо:** | | | | 65.6 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Багшлах эрхийн сургалтад хамрагдах | 100 | 15 | |
| 2. | Эрсдэлийн удирдлагын хэлтсийн чиг үүрэг болон олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийг судлах | 100 | 15 | |
| Дундаж оноо: | | | 15 | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 6.5 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 6.5 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6.5 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 6.5 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 6.5 | |
| **Дундаж оноо:** | | **6.5** | |

## 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|

220

| | 1 | 2 |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 7.5 |
| 2 | Багаар ажиллах | 7.5 |
| 3 | Харилцаа | 7.5 |
| **Дундаж оноо: 7.5** | | |

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *65.6* |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6.5 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 7.5 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =94.6** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ (Д.Цэндсүрэн)

2024.12.10 ................ (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч ................................ (Н.Энхтайван)

2024.12.10 ................ (огноо)

***Үнэлгээг хянасан:***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр

221

орлон гүйцэтгэгч .................................... (Г.Энхтайван)

XII/20, 2024 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч .................................... (Ө.Тэгшээ)

2024. 12. 20 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***

Гаалийн ерөнхий газрын дарга .................................... (Р.Отгонжаргал)